Golomt Capital®
Delivering diversity

Interactive Brokers

# ТОЙМ



## ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2024.04.22

*Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв*

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

2024 он 04-р сарын 22

## ТОВЧ

- Борлуулалт буурч байгаагаас шалтгаалж Tesla компани дэлхий даярх ажилчдынхаа 10%-ийг цомхотгоно
- TSMC компанийн 2-р улирлын борлуулалт AI-ийн ханашгүй эрэлтийн улмаас өсөх хүлээлттэй байна
- Тегераны зүгээс Израйлын довтолгоог чухал гэж үзэхгүй байгаа бөгөөд хариу арга хэмжээ авах магадлал бага байна
- ХНС-ийн тэргүүн Жером Пауэллийн мэдэгдсэнээр бодлогын хүүг өндөр хэвээр удаан хадгалах магадлал өндөр байгаа ба сүүлд гарсан инфляцын тоон мэдээ нь эдийн засагт тодорхойгүй байдлыг ахин үүсгэлээ.

| | |
|---|---|
| Dow Jones | 37,986.40 |
| S&P 500 | 4,967.23 |
| Nasdaq | 15,282.01 |
| DAX | 17,742.36 |
| FTSE 100 | 7,895.85 |
| S&P/ASX 200 | 7,649.20 |
| HANG SENG | 16,224.14 |

### АНУ-ын индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| Dow Jones | 0.56% | 0.67% | -3.77% | 0.79% | 12.36% | 11.58% |
| S&P 500 | -0.88% | -1.87% | -5.10% | 4.14% | 20.17% | 18.83% |
| Nasdaq | -2.05% | -3.80% | -6.98% | 1.80% | 26.59% | 9.03% |

2024 оны 04 сарын 22-ны 15:30



### Европын индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| DAX | 0.50% | -1.04% | -2.02% | 6.49% | 12.32% | 16.75% |
| FTSE 100 | 1.21% | 0.30% | 0.74% | 3.32% | 0.96% | 15.15% |

2024 оны 04 сарын 22-ны 15:30



### Ази Номхон далайн индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| S&P/ASX 200 | 1.08% | -1.33% | -1.56% | 0.77% | 4.35% | 8.33% |
| Hang Seng | 1.94% | -0.35% | 0.26% | -2.96% | -17.60% | -43.11% |

2024 оны 04 сарын 22-ны 15:30



# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

АНУ-ын төв банкны бодлогын хүү хүлээлтээс удаан хугацаанд өндөр байх магадлалтай байна. Мөн ойрх дорнодод үүсэж байгаа хурцадмал нөхцөл байдлаас гадна бодлогын хүүгийн хүлээлтээс шалтгаалан АНУ-ын индексүүд 3 дах долоо хоног дараалан уналаа. Бодлогын хүү удаан хугацаанд өндөр байх нь технологийн аваргуудын цаашдын орлогод сөрөг үр дагавартай.

Дэвшилтэт чип үйлдвэрлэгч ASML холдингийн эхний улирлын орлого шинжээчдийн хүлээлтэд хүрч чадаагүй нь тус компанийхтай ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг бусад компанийн хувьцааны ханшид сөрөг нөлөө үзүүллээ.

Эдийн засгийн зарим хүчтэй мэдээллүүд нь Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ бууруулах арга хэмжээг 2025 он хүртэл сунгана гэсэн болгоомжлолыг нэмэгдүүлсэн. Даваа гарагт Худалдааны яамны мэдээлснээр жижиглэнгийн борлуулалт гуравдугаар сард 0.7%-иар өссөн нь хүлээлтээс хамаагүй өндөр байв. Шатахууны үнийн өсөлт нь зарим талаараа нөлөөлсөн боловч ресторан, баар, онлайн жижиглэн худалдаа гэх мэт ерөнхийдөө өргөн хүрээтэй байжээ.

Эсрэгээр, гуравдугаар сард орон сууцны зөвшөөрөл хүлээгдэж байснаас хамаагүй доогуур гарч, сүүлийн долоон сарын хамгийн доод түвшинд хүрчээ. 30 жилийн хугацаатай орон сууцны зээлийн дундаж хүү 12-р сараас хойш анх удаа 7%-иас дээш гарсан тул одоо эргэлтэд байгаа орон сууцны борлуулалт буурчээ.

**График 1: NASDAQ100 индекс**




4 сарын 12-ноос хүчтэй уналтын чиг хандлагын эрч саараагүй байна. Энэ сард технологийн аваргууд тайлангаа танилцуулах тул зах зээл хөндлөн чиглэлийн хөдөлгөөн ажиглагдах боломжтой.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

**БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛ**

**Индексүүд:** БНХАУ-ын 2024 оны 1-р улирлын эдийн засгийн өсөлт 5.3% буюу хүлээлтээс өндөр гарснаар Shanghai Composite index 1.52%, CSI 1.89% өссөн бол Hang Seng индекс 2.89% хувиар уналаа. Өнгөрсөн 4-р улиралд БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 5.2% байсан ба 2024 оны эхний 3 сард өмнөх улирлаасаа эдийн засаг 1.6% өсөлт үзүүлжээ.

**Эдийн засгийн үзүүлэлт:** Түүнчлэн 3-р сард аж үйлдвэрлэл 4.5% өссөн нь хүлээлтийг эвдэж чадаагүй бол жижиглэн худалдааны өсөлт 3.1% гарсан нь мөн ч хүлээлтээс доогуур үзүүлэлт болжээ. Цагаан сараас хойш БНХАУ-ын кэтеринг болон автомашины борлуулалт буурсан нь жижиглэн худалдаа буурахад голчлон нөлөөлсөн байна. Харин үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт хүлээлтээс давж өссөн ч үл хөдлөхийн хөрөнгө оруулалт өмнөх оноос 9.5% буурлаа. БНХАУ-ын залуучуудын ажилгүйдлийн түвшин 15.3%, хотын ажилгүйдлийнн түвшин 5.2% болж тогтворжсон байна.

**Мөнгөний бодлого:** БНХАУ-ын ардын банкны 100 тэрбум юанийн дунд хэмжээний бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн эх үүсвэрийг зах зээлд нийлүүлсэн ба зээлийн хүүгийн түвшин өөрчлөгдөөгүй хэвээр байна.

**Үл хөдлөх хөрөнгө:** БНХАУ-д шинэ байрны үнэ 3-р сард 0.3%-иар уналаа. Зохицуулагчдын зүгээс орон сууц авахыг дэмжихэд зориулсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээд буй ч шинжээчдийн зүгээс үл хөдлөхийн салбар нь эдийн засгийг хойш татагч үзүүлэгч хэвээр байгааг онцолж байна.

### График 2: TSMC хувьцааны ханшийн график ба техник шинжилгээ




Taiwan Semiconductor Manufacturing Company нь хөрөнгө оруулахад дараах 2 давуу талтай байна:

- Дэлхийн хагас дамжуулагчийн салбарын хамгийн чухал компани – AI технологийн гол амин судас
- Дэлхийн most advanced чипний зах зээлийн 90%-ийг хангадаг

# ТАЙЛАНГИЙН ХУАНЛИ

## Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд




## Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

